

“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХК-ИЙН ХУВЬЦАЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дүгээр сарын 29

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаа 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр “Улаанбаатар хот, 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж, 39-2 “Велокс” оффисын 8 давхрын 803 тоот өрөөнөөс цахимаар хийгдэв.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг явуулах болсон шаардлага, шалтгаан, хурлын бэлтгэлийг хэрхэн хангаж ажилласан талаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Оюунгэрэл танилцуулав.

ТУЗ-ийн шийдвэрээр байгуулагдсан Тооллогын комисс Хурлын ирцийг гаргаж, тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдээс 7 997 200 ш саналын эрх бүхий Тэс трейд ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Н.Чулуунчимэг, 435 689 ш хувьцаа эзэмшигч Х. Гэрэлт-Од, 7000 ш хувьцаа эзэмшигч А.Тэлмэн, 100 ш хувьцаа эзэмшигч С.Оюунгэрэл, 57 ш хувьцаа эзэмшигч Н.Мөнхсүрэн, 547 058 ш хувьцаа эзэмшигч Д.Дуламсүрэн, 100 ш хувьцаа эзэмшигч Ж. Баттулга нар цахим хуралд оролцсон бол, 7806 ш хувьцаа эзэмшигч Д.Мөнхтөр, 937 532 ш хувьцаа эзэмшигч М.Золзаяа, 426 779 ш хувьцаа эзэмшигч Б.Цацрал, 2 хувьцаа эзэмшигч М.Шигшээ, 2 хувьцаа эзэмшигч С.Дашдорж нар урьдчилж саналын хуудсаар саналаа бөглөж ирүүлсэн байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2020 оны 4 сарын 6-ны өдрөөр тасалбар болгон авсан бүртгэлээр тус компанийн нийт хувьцаа эзэмшигч: 386

Хувьцааны тоо : 15 734 200

Үүнээс “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн халаасны хувьцаа болох 783,545 ширхэг хувьцааг хасаад нийт санал өгөх эрхтэй хувьцаа 14 950 655 ширхэг байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 10359325 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 12 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 14 950 655 ширхэг энгийн хувьцааны 69.3 хувь болж байгааг хурлын даргад мэдээлэв.

2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн хурлын тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Н.Ерөөгэрэлийг томилсон тул хурлыг даргалж явуулав.

Н.Ерөөгэрэл- Хурлын дарга.

Өнөөдрийн цахим хуралд оролцож байгаа Та бүхэнд баярлалаа.

Хурлын ирц хуульд заасан шаардлагад хүрсэн тул Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээснийг мэдэгдье.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулъя. Дэлгэцэнд гаргав.

Хэлэлцсэн асуудал: ТУЗ-ийн 2019 онд хийсэн ажлын талаар ТУЗ-ийн дарга Н.Ерөөгэрэл танилцуулав.

Танилцуулгыг хавсаргав.

Асуулт, хариулт гараагүй болно.

Хэлэлцсэн асуудал: Хувьцаа эзэмшигчдэд 2019 онд ногдол ашиг тараасан талаар болон 2020 онд ногдол ашиг тараахгүй байх тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаар товч мэдээлэл

ТУЗ-ийн дарга Н.Ерөөгэрэл

\ Холбогдох танилцуулга, бусад материалыг хавсаргав \

Асуулт: Тэс трейд ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Чулуунчимэг

2019 онд нийтдээ 1.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаас 1.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараасан гэж хэллээ. Үлдсэн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг яах юм бэ?

Н.Ерөөгэрэл- Компанийн санхүүгийн тайланд өглөг үүсгээд явж байгаа. Үлдэгдэл 200 сая төгрөгийг тухайн хувьцаа эзэмшигч хүсэлтэй гаргасан тухай бүрт олгоод явна. Зарим хувьцаа эзэмшигчид хүсэлтээ гаргаагүй байгаа гэж ойлгож болно.

А.Тэлмэн- 2019 онд ногдол ашиг хувиарласанд хувьцаа эзэмшигчид баяртай байгаа. 2020 онд яагаад ногдол ашиг хувиарлахгүй байгаа юм бэ? 2020 онд хуваарилаагүй ашгийг 2021 онд ногдол ашиг болгож авах хуваарилах уу?

Н.Ерөөгэрэл- Аудитын тайлангаар компани 2019 онд 1.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан гэсэн дүн гарсан. Гэвч энэ нь мөнгөн хэлбэрээр байгаа гэсэн үг биш юм. Оны эцсийн байдлаарх бэлэн мөнгөний үлдэгдэл 142 сая төгрөг байна. 2019 онд 700 сая төгрөгийн зээл төлсөн, техник төхөөрөмж авсан, буудай худалдан авсан. Ногдол ашгийг бэлэн мөнгөөр хуваарилах нь компанийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварт муугаар нөлөөлнө. Компани 2020 онд гурилын үйлдвэрлэлээ өсгөхийн тулд эргэлтийн хөрөнгөө зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай байна. Гурилын үйлдвэрлэл өссонөөр компанийн ашиг орлого нэмэгдэж, төлбөрийн чадвар сайжирснаар цаашдаа ногдол ашиг хуваарилах боломж бүрдэнэ гэж үзсэн болно. Гэхдээ 2020 оны санхүүгийн үр дүн ямар байхаас 2021 онд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр хамаарна.

Хэлэлцсэн асуудал: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн талаар танилцуулав.

Н.Ерөөгэрэл- Энэ жилийн хувьд ТУЗ-өөс өгөх дүгнэлтийг нилээд дэлгэрэнгүй, судалгаатай, компанийн үйл ажиллагаанд бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор хийсэн. Компанийн удирдлагын зүгээс хийж, хэрэгжүүлж байгаа ажлыг онцлохын зэрэгцээ, цаашид ямар асуудалд нарийн анхаарч ажиллах талаар хэд, хэдэн зөвлөмжийг өгч ажиллах нь зүйтэй гэж үзсэн юм. ТУЗ-өөс 2019 онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцсон.

Асуулт, хариулт гараагүй болно.

Хэлэлцсэн асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

С.Оюунгэрэл-Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд 2 жилийн хугацаатай байхаар Компанийн дүрэмд заасан байна. ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшүүлэх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж танилцуулахын тулд одоо ажиллаж байгаа Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшигчдийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, анкетын загвар боловсруулан өөрийн компанийн пайж хуудаст зар оруулж ажилласан. Мөн ТУЗ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу бэлтгэл ажлыг зохион

байгуулсан. Нэр дэвшүүлэх хорооны нэр дээр 2 хүний материал ирсэн байна. Одоо ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүдээсээ цаашид ТУЗ-ийн гишүүнээр үргэлжлэн ажиллах бодолтой байгаа эсэх талаар саналыг авч ажилласан. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн хувьд ТУЗ-ийн гишүүн нь дээд боловсролтой, хууль эрх зүй, санхүү, бизнесийн зохих түвшний мэдлэгтэй, хууль, тогтоомж, дүрмээр тогтоосон үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, боловсрол, дадлага туршлагатай байх, одоогийн болон өмнө эрхэлж байсан ажил албан тушаал, туршлага, харилцаа холбооны хувьд компанитай ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх гол шаардлагыг тавьж ажилласан. Компанийн үндсэн бизнест өөрийн мэдлэг туршлагаар хувь нэмэр оруулах боломжтой, бизнесийн удирдлага, бизнесийн эрх зүй, ХАА, хүнсний үйлдвэрлэлд ажиллаж байгаа болон өмнө нь ажиллаж байсан бол давуу тал байна гэж онцолсон болно. Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн хувьд Компанийн тухай хуульд тавьсан шаардлагыг хангасан хүмүүсийг сонгож Та бүхэнд танилцуулж байгаа юм.

Н. Ерөөгэрэл- Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байгаа 9 хүний 2 нь шинээр нэр дэвшигчид байна. Бусад 7 хүн нь өмнө нь компанийн ТУЗ-д ажиллаж байсан, компанийн ажлыг сайн мэддэг, ХАА, газар тариалан, хууль эрх зүй, санхүү, эдийн засгийн мэдлэгтэй, туршлагатай хүмүүс байгаа болно.

Хувьцаа эзэмшигчид Та бүхэн нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг өмнө нь тараасан материал болон дэлгэц дээр гарч байгаа танилцуулгаас харах боломжтой юм.

Хүн нэг бүрээр танилцуулав. \

Асуулт гарсангүй.

Хэлэлцсэн асуудал: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын талаарх танилцуулга ТУЗ-ийн дарга Н.Ерөөгэрэл хийв.

Асуулт, хариулт явагдаагүй болно.

Л.Чулуунчимэг- Өөр нэг асуудал байна. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, 2020 оны төлөвлөгөөг хэлэлцэх ёстой юу?

Н.Ерөөгэрэл- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2020 оны төлөвлөгөөг ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн. Зохих шийдвэрийг гаргасан. Бид Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг ном хэлбэрээр хэвлүүлж хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн. Мөн Тариалан суманд компанийн байранд дээр нилээд олон хувь хувилуулж хүргүүлсэн байгаа. Гэхдээ одоо 2020 оны зорилтын талаар та бүхэнд товч мэдээлэл хийе гээд танилцуулав.

Хурлын дарга- Удахгүй санал хураах ажилдаа орно. 3 асуудлаар тогтоол гарна.

Ердийн аргаар саналын хуудсыг бөглөх 2 асуудал байгаа.

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн талаар

- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын талаар

Кумулятив аргаар:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудал байна.

Тооллогын комиссоос – Санал хүлээн авах үйл ажиллагааг эхлүүлэв.

Саналын дүнг нэгтгэх ажил явагдах хугацаанд түр завсарлага хийв.

Саналын хураалтын дүнгийн талаар Тооллогын комиссын дарга Т.Жавзанжимдаан танилцуулав.

Н. Ерөөгэрэл-Тооллогын комиссын дүнд хувьцаа эзэмшигчийн тоо өөр байна. Ямар учиртай юм бэ?

Т.Жавзанжимдаан: Нийт 12 хүн хурлын эхэнд байсан. Нэг хувьцаа эзэмшигч цахим хуралд сууж байсан боловч саналаа өгөөгүй дундаас нь гарсан байна. Нэг хувьцаа эзэмшигчийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох саналын хуудсыг бөглөсөн хүснэгт буруу бөглөсөн учир хүчингүй болсон байгаа.

Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн одоо ХЭХ-аас гарах тогтоолын төслийг уншиж, батлуулъя.

Тогтоолын төсөл дээр өөр саналтай хүн байна уу? Байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолуудыг батлав.

Хуралд оролцсон Та бүхэндээ баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурал хаасныг мэдэгдье.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 18 цаг 35 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Хурлын дарга

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Н.Ерөөгэрэл

С.Оюунгэрэл